



СЕКЮРИТИЗ
ҮЦК

2022.08.22-2022.08.26

ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ



2022.08.29-ний pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	32,073.00	-0.65%	-3.01%	-2.22%	-9.41%
US500	4,026.77	-0.77%	-2.73%	-2.27%	-11.12%
NASDAQ	13,463.00	-1.12%	-3.35%	-3.72%	-20.16%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	7,427.00	-0.70%	-1.63%	1.08%	3.91%
DE40	12,971.00	-2.26%	-4.23%	-1.48%	-18.17%
FR40	6,274.00	-1.68%	-3.41%	0.26%	-6.10%
IT40	21,895.00	-2.49%	-2.84%	1.93%	-15.81%
ES35	8,064.00	-1.51%	-3.29%	-0.74%	-9.62%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	27,848.00	-2.76%	-3.19%	-0.47%	0.21%
SHANGHAI	3,233.00	-0.09%	-1.30%	-0.76%	-8.30%
CSI 300	4,087.00	-0.51%	-2.17%	-2.34%	-15.01%
SHANGHAI 50	2,730.00	-0.77%	-0.82%	-1.72%	-12.17%
CH50	13,455.71	-1.08%	-1.72%	-2.00%	-9.28%
SENSEX	58,834.00	0.10%	-1.36%	5.41%	4.83%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	94.32	1.35%	4.39%	2.10%	36.29%
Газрын тос (Brent)	101.76	0.76%	5.49%	1.74%	40.90%
Байгалийн хий	9.56	2.79%	-1.28%	15.37%	121.98%
Шатахуун	2.87	0.51%	-0.90%	-4.44%	33.03%
Нүүрс	417.40	-0.02%	0.28%	1.43%	144.17%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,726.51	-0.60%	-0.52%	-2.54%	-4.61%
Мөнгө	18.66	-1.18%	-1.88%	-8.29%	-22.48%
Зэс	3.64	-2.06%	-1.02%	2.28%	-16.70%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	3.1191	0.0841	0.09%	0.52%	1.84%
Англи	2.6060	0.0120	0.19%	0.65%	2.03%
Швейцар	0.8450	0.0490	0.16%	0.30%	1.18%
Испани	2.5960	0.1010	0.22%	0.44%	2.37%
Португали	2.4960	0.0870	0.20%	0.43%	2.31%

Зун дуусах тал руугаа орж байгаа боловч хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл үргэлжилсээр байна

Хөрөнгийн зах зээл энэ зун ихээхэн савлагаатай байлаа. Томоохон индексүүд 6 сард баавгайн зах зээлд орсон боловч 7 сард нэлээд өсөж, 8 сарыг харьцангуй тогтмол үдэх бололтой. Хэдийгээр хамгийн гутранги төсөөллөөс ангижирсан ч өсөлтөд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс хэвээрээ байна. Холбооны Нөөцийн Сангийн (ХНС) Баасан гарагийн Жаксон Хөүлийн мэдэгдлээр хөрөнгийн зах зээл ямар хариу үйлдэл үзүүлснийг харцгаая.

1. Юу өөрчлөгдсөн бэ? Инфляц оргил түвшиндээ хүрч, одоо буурах хандлагатай байна

Инфляцын түвшин 6 сараас хойш харьцангуй буурсан үзүүлэлттэй байгаа нь үүссэн сөрөг нөхцөл байдлыг бага зэрэг сайжрахад нөлөөлсөн гэж үзэж байна. Компаниудаас авсан санал асуулга болон эдийн засгийн мэдээнүүдээс харахад нийлүүлэлтийн гацаа дээрдэж эхэлсэн боловч эрэлт буурч байгааг илтгэж байна.

Жишээлбэл, түүхий эд болон тээвэрлэлтийн зардал сүүлийн 3 сард унаж байгаа нь үнийн өсөлтийг сааруулахад хувь нэмэр оруулж байна. Шинээр гарсан худалдан авалтын менежерийн индексээр (PMI) аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлтийн хугацаа, үнэ буурсан талаар дурджээ. Эдийн засгийн өсөлт саарч, бараа материалын үлдэгдэл борлуулалттай харьцуулахад илүү байгаа нь юмны үнэ буурахад эергээр нөлөөлнө. Богино болоод урт хугацааны инфляцын хүлээлт буурч байгаа нь ХНСанг цаашид бодлогын хүүг хэтэрхий ихээр өсгөх шаардлагагүй гэдгийг илэрхийлж байна.

Юу өөрчлөгдөөгүй вэ? ХНС-ийн инфляцын түвшний төсөөлөл 2%-иас хэтэрхий их байна

ХНС-ийн дагадаг инфляцын хэмжүүр болох PCE дефлятор 2022 оны 7 сарын байдлаар 6.3%-тай байгаа нь өнгөрсөн жилийн мөн үеийн 6.8%-иас буурсан үзүүлэлттэй байна. Хоол, хүнс болон эрчим хүчний үнийг оролцуулаагүй инфляцын түвшин 4.6%-тай байгаа нь ХНС-ийн зорилтот дүн болох 2%-иас хоёр дахин илүү байна.

Бараа, материалын үнэ буурах хандлагатай байгаа ч үйлчилгээний үнэ ханш буурах болоогүй байна. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл уналтад орсон боловч түрээсийн үнэ харьцангуй удаан буурах хандлагатай. Дээрээс нь түүхий эдийн ханш геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан яаж ч магадгүй.



2. Юу өөрчлөгдсөн бэ? ХНС зорилтот бодлогын хүү хүртэл өсгөсний дараагаар буулгаж эхэлнэ

Эрх баригчид мөнгөний бодлогын хариу үйлдэл хэтэрхий удаан байсныг хүлээн зөвшөөрснөөр, энэ жил хурдтай нэмж эхэлсэн билээ. Бодлогын хүүг шат дараалалтай (3 сард 0.25%-иар, 5 сард 0.5%-иар, 6 сард 0.75%, 7 сард 0.75%) нэмж 2.25%-2.50% хүргэснээр хэт хатуу эсвэл зөөлөн биш, дундын хэмжээнд аваачсан гэж үзэж байна. Энэхүү хурдтай өсөлт нь АНУ-ын сүүлийн 40 жилд үзэгдээгүй явдал юм.

ХНС-ийн ерөнхийлөгч Жером Пауэллийн Жаксон Хөүл дэх мэдэгдлээр инфляцыг хяналтад оруулахаар хатуу мөнгөний бодлогыг тодорхой хугацаанд барихаас өөр аргагүй байгааг хэлсэн. Инфляц болон эдийн засгийн өсөлт хоёулаа хэцүүхэн байдалд байгаа нь бодлогын хүүгийн өсөлтийг бага зэргээр сааруулж магадгүй. Жером Пауэлл дараа сард бодлогын хүүг 0.5% эсвэл 0.75%-иар өсгөхөө мэдэгдээгүй. Удахгүй гарах ажлын байр болон инфляцын мэдээгээр энэ 9 сард бодлогын хүү хэдэн хувиар өсөх нь илүү тодорхой болох байх.

АНУ-ын засгийн газрын үнэт цаасны өгөөж болон бодлогын хүү



Юу өөрчлөгдөөгүй вэ? Бодлогын хүү буурах нөхцөлийг хангах шаардлага өндөр

Зун ажиглагдсан хөрөнгийн зах зээлийн өсөлт сүүлийн 2 долоон хоногт зогссон нь шинжээчдийн 2023 оны сүүлийн хагас жилд бодлогын хүүг зөөлрүүлэх хүлээлт бүтэхээргүй болсонтой холбоотой байв. Шинжээчдийн дунд бодлогын хүү ирэх 6 сард 3.75%-4.00% хооронд байх таамагтай байгаа нь эрх баригчдын 2023 оны төсөөлөлтэй нийцэж байна.

Бодлогын хүү өссөөр байхад, төв банкны балансын үлдэгдэл 9 сард хурдтай агших магадлалтай байгаа нь 10 жилийн ЗГ-ын үнэт цаасны өгөөжийг 3.50%-иас давж магадгүй гэсэн хүлээлт үүсгэж байна. Өмнө ажиглагдаж байсанчлан ЗГ-ын үнэт цаасны өгөөж бодлогын хүүгээс өмнө дээд цэгтээ хүрч магадгүй.

3. Юу өөрчлөгдсөн бэ? Эдийн засаг унаж байгаа боловч төсөөлж байснаас илүү тэсвэртэй

Бодлогын хүү болон инфляц өсөж байгаа өнөөгийн үед эдийн засаг уналттай байсаар байна. Гэсэн хэдий ч худалдан авагчдын хэрэглээ өссөөр байгаа нь АНУ-ын эдийн засгийг тэтгэж байна.

2-р улирлын эргэн шалгасан тайлангаар ДНБ-ний уналт бага зэргийн өсөлттэй гарсан нь худалдан авалт сайн байгааг харуулж байна. Үйлчилгээний зарцуулалт 3.6%-ийн өсөлттэй байсан нь худалдан авалтыг 1.5%-иар нэмэгдэхэд нөлөөлжээ. Өрхийн орлого 7 сард өсөлттэй байсан нь хөдөлмөрийн зах зээлийг тогтвортой байгааг харуулж байна. Харин ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өсөж, шинээр зарлагдаж байгаа ажлын байрны зарлал буурч байгаа.

АНУ-аас өөр бусад хөгжингүй орнуудын эдийн засаг ойрын үед өсөхгүй байх хандлагатай. Орос-Украины дайнаас үүдэлтэй байгалийн хийн ханш өнгөрсөн сард огцом өссөн нь Европын орнуудын эдийн засаг жилийн эцсээр хямралд орох эрсдэлийг нэмэгдүүлсээр байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт тэг Ковид болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналтаас үүдэж удаашрах хандлагатай.

Байгалийн хийн ханш



4. Юу өөрчлөгдсөн бэ? Компаниудын ашгийн төсөөлөл буурч байгаа нь хөрөнгийн зах зээлийн ёроол ханш тогтоход нөлөөлнө


S&P 500 компаниудын 95% нь хагас жилийн тайлангаа танилцуулснаар компаниудын ашиг жилийн өмнөхөөс 8.5%-иар өссөнийг харуулж байна. Ихэнх өсөлтийг эрчим хүчний компаниуд үзүүлэв.

Өнгөрсөн 1 сарын хугацаанд S&P 500 компаниудын 2022 оны ашгийн төсөөлөл 10%-иас 8.5% болж буурсан бол 2023 оны төсөөлөл 9.5%-ийн өсөлтөөс ердөө 7.7% болон буурав. Өрхийн санхүүгийн нөхцөл байдал сайн байгаа нь аж ахуйн нэгжүүдийн ашиг буурахаас сэргийлэх боловч дараа жил хэр хамгаалж чадахыг таахад бэрх байна.

Юу өөрчлөгдөөгүй вэ? Ашигт ажиллагаанд тулгарах бэрхшээлүүд үргэлжилсээр байх болно

Өнгөрсөн улирлын борлуулалт инфляцын өсөлтөөс болж сайн байлаа. Ашгийн маржин өнгөрсөн улирал болон өнгөрсөн жилийн мөн үеэс буурсан. Түүхий эдийн ханшийн уналт бизнесүүдийн ашигт ажиллагаанд нэмэр болж байгаа ч цалингийн зардал болон үйлдвэрлэл буурсаар байна.

S&P 500 компаниудын ашгийн маржин



Ирэх саруудад хэрхэн бэлтгэлтэй байх вэ?

Хөрөнгийн зах зээл энэ зуныг санаж байснаас илүү сайн байр суурьтай үдлээ. Шалтгаан нь инфляцын түвшин, бондын өгөөж, хэлбэлзлийн бууралтаас болсон. ХНС бодлогын хүүг өсгөхөө зогсохоос нааш ёроол ханш тогтохгүй. Өнгөрсөн явдлаас харахад 9, 10 саруудад хэлбэлзэл ихтэй байсан. Хөрөнгийн зах зээл 11 сараас эхлэн хүчтэй өсдөг тул урт хугацаандаа хөрөнгө оруулснаар өгөөж хүртэнэ.